



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 268


Улаанбаатар хот

“Юу Энд Эн” ХХК-ийн даатгалын хохирол  
үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Юу Энд Эн” ХХК-ийн даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Хүчингүй болгосон даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Юу Энд Эн” ХХК /Ж.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН